

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АГУУЛГА

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

1.1 Төрийн аудитын бодлого, стратеги	3
1.2 Төрийн аудитын бүрэн эрх	4
1.3 Сэлэнгэ аймгийн төрийн хяналтын байгууллагын түүхэн товчоон	5
1.4 Байгууллагын бүтэц, орон тоо	7

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Үйл ажиллагааны чиг үүрэг	8
2.2 Үйл ажиллагааны хамрах хүрээ	10
2.3 Төрийн аудитын нээлттэй, ил тод байдал	11



1.1 ТӨРИЙН АУДИТЫН БОДЛОГО, СТРАТЕГИ



АЛСЫН ХАРАА

Монгол Улсын хөгжлийн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн өндөр үр нөлөөтэй төрийн аудитыг гүйцэтгэж, арга зүй, технологи, үйл ажиллагаагаар бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх аудитын дээд байгууллага болно.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлж, харилцагч талуудын хамтын ажиллагааг сайжруулах замаар иргэдийн амьдралыг сайжруулна.

ЭРХЭМЛЭХ ҮНДСЭН ЗАРЧИМ



СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2019-2024 ОН

	Төрийн аудитын байгууллагын хараат бус байдал, хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх
	Төрийн аудитын тогтолцоонд арга зүй, стандартын шинэчлэл хийж, олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцсэн дэвшилтэт технологи бүхий орчин үеийн төрийн аудитын тогтолцоог төлөвшүүлэх
	"Алсын хараа"-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, төрийн аудитын байгууллагын идэвх оролцоог нэмэгдүүлэх замаар сайн засаглалыг дэмжих, төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг хараат бусаар явуулах эрх зүйн болоод арга зүй, технологийн таатай орчныг бүрдүүлэх
	Харилцагч талуудтай ажиллах тогтолцооны үр нөлөөг сайжруулах
	Нийгмийн бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээний асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх
	Төрийн аудитын байгууллагын дотоод засаглал, дэмжих үйлчилгээ, эрсдэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх

1.2 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

Төрийн аудитын байгууллагын чиг үүргийг төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх гэж Монгол Улсын Үндсэн хуульд заасан юм.

Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Төрийн аудитын тухай хуулиар тогтоох бөгөөд аудитын байгууллагад Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиар тодорхойлсон төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд хамаарахгүй чиг үүрэг нэмэгдүүлэхийг хориглодог.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ДАРААХ БҮРЭН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ

» Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу дараах аудитыг гүйцэтгэнэ.



Санхүүгийн
тайлангийн
аудит



Гүйцэтгэлийн
аудит



Нийцлийн
аудит



Бусад
аудит

» Улс, орон нутгийн төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах

» Төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд хуульд заасан болон шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар аудит хийх

“Төрийн санхүү, төсвийн хяналт” гэж төрийн санхүү, төсөв, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, эргэн төлөгдөх нөхцлөөр ашиглуулах үйл ажиллагаа, хувьчлал, дуудлага худалдаа, техник, эдийн засгийн үндэслэл, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, зээллэг, гадаад зээл, тусламж, хандив,

санхүүгийн дэмжлэг, өрийн баталгаа, үнэт цаас, бүх төрлийн гэрээ, хэлцэл болон бусад аливаа үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, ашиглалт, зарцуулалт, хэрэгжилт, тайлагнал болон нийтийн өмчтэй холбоотой бүх үйл ажиллагаанд төрийн аудит хийх үйл явц юм.

» Нийтийн өмчтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актыг боловсронгуй болгох, батлан гаргах талаар эрх бүхий этгээдэд зөвлөмж өгөх

“Нийтийн өмч” гэж нийтийн ашиг сонирхлын төлөө ашиглагдах иргэдэд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, түүний баялаг, ой, ус, ургамал, ан амьтны нөөц, эрдэнэсийн сан, төсвийн орлого, нийтийн болон тусгай сан, төрийн болон

орон тугийн өмчид хамаарах эдийн болон эдийн бус хөрөнгө, хуулиар нийтийн зориулалтаар ашиглах өмчид хамаарах бусад хөрөнгийг хэлнэ.

1.3 СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨРИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХЭН ТОВЧООН

Монгол Улсад төрийн хяналтын байгууллагын үндэс суурь нэгэн зууны өмнө буюу тэртээ 1922 онд тавигдаж, нийгмийн тогтолцооны өөрчлөлт түүхэн цаг хугацааны явцад хөгжлийн олон сорилтуудыг даван туулж бүтэц зохион байгуулалт нь өөрчлөгдөж иржээ.

Сэлэнгэ аймгийн Төрийн хяналтын байгууллагын сүүлийн 50 жилийн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг харуулбал:

1972

Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1972 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 210 дугаар зарлигаар БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн Хянан шалгах комиссыг татан буулгаж, Ардын Хянан Шалгах Хороог байгуулсантай холбогдуулж Сэлэнгэ аймагт Ардын хянан шалгах хороог байгуулж, даргаар нь н.Жигжидсүрэнг томилжээ. 1978-1990 оны хооронд тус хорооны даргаар С.Лханаа ажилласан байна.



Сэлэнгэ аймгийн Хянан байцаах албаны дарга
Ж.Санжжав /1991 он/

1995

УИХ-аас 1995 оны 3 дугаар сарын 27-ны өдөр "Төрийн хяналт, шалгалтын тухай" хуулийг баталж, 1995 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлснээр тус оны 8 дугаар сараас аймгийн Төрийн хянан шалгах хороо үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд тус газрын даргаар Я. Гүрсүрэнг томилсон байна.



Ардын хянан шалгагчдын улсын анхдугаар
хуралдааныг нээж АХШХ-ны дарга Ц.Молом үг
хэлж байгаа нь /1982 он/

1991

БНМАУ-ын АИХ-ын 1990 оны 29 дүгээр тогтоолоор Ардын хянан шалгах байгууллагуудыг татан буулгахаар шийдвэрлэсний дагуу 1991 оны 1 дүгээр сарын 1-нээр тасалбар болгон аймгийн Ардын хянан шалгах хороог татан буулгаж аймгийн Ардын хурлын гүйцэтгэх захиргааны Хянан байцаах албыг байгуулан даргаар нь Ж.Санжжавыг томилсон бөгөөд 1992 онд тус албыг татан буулгасан байна.



ТХШХ-ны хамт олон
1995-2002 он

2003

УИХ-ын 2003 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн хуралдаанаар Төрийн аудитын тухай хуулийг баталснаар аймгийн Төрийн хянан шалгах хороог аймгийн Аудитын газар болгон зохион байгуулж аймгийн ерөнхий аудитораар 2003-2004 онд О.Зандраа, 2004-2013 онд Ч.Насанбат ажиллаж байсан байна.



Аудитын газрын хамт олон
2003-2004 он



Аудитын газрын хамт олон /2004-2013 он/



Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын
хамт олон /2014 он/


2017

Монгол улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/59 дугаар “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрыг өөрчлөн байгуулах” тухай тушаалаар УАГ-ын харьяа Сэлэнгэ аймгийн Аудитын газрыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар болгон зохион байгуулж дарга, тэргүүлэх аудитораар Ч.Энхтуяаг томилжээ.



Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын
хамт олон /2017 он/

1.4 БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ОРОН ТОО



Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын хамт олон /2021 он/

Төрийн аудитын байгууллага нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх бөгөөд Төрийн аудитын дээд байгууллага буюу Үндэсний аудитын газар, түүний харьяа аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газраас бүрдэнэ.

Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо баталдаг.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер болон ахлах аудитор - 3, аудитор - 6, жолооч, нягтлан бодогч - бичиг хэрэг хариуцсан гэрээт ажилтан гэсэн нийт 13 албан хаагчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Нийт албан хаагчдын 50 хувь, төрийн тусгай албан хаагчдын 54.5 хувь нь мэргэшсэн нягтлан бодогч юм.

2.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ҮҮРЭГ

Төрийн аудитын байгууллага нь Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудитуудыг хийж гүйцэтгэн дүгнэлт гарган алдаа зөрчлийг арилгах, төсвийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэн ажиллах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

АУДИТЫН ТӨРӨЛ

Төрийн аудитын байгууллага төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд дараах гурван төрлөөр аудит хийдэг. Үүнд:



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүүгийн аудит нь шалгагдагч этгээд санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж баталгаажуулна. Санхүүгийн тайлангийн аудит бүхэлдээ төрийн мөнгөний үнэ цэнийг сайжруулахад чиглэдэг.



Санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх



Санхүүгийн тайланг зохих стандарт, шаардлагын дагуу бэлтгэсэн эсэх талаар хараат бус дүгнэлт гаргах



Шалгагдсан байгууллагын санхүү, нагтлан бодох бүртгэл, тайлагнал зохих шаардлагад нийцэж байгаа эсэх талаар үндэслэлтэй баталгаа, мэлээллээр хууль тогтоох байгууллагыг хангах

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийх аудит

Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд хийх аудит

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийх аудит

Санхүүгийн тайлангийн аудитын хамрах хүрээ, аудит хийх шатлал болон хэлбэр:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийх аудит

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийх аудит

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийх аудит



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Гүйцэтгэлийн аудитын зорилго

Төрийн аудитын байгууллага шалгадагч этгээдийн бодлого, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй эсэхэд аудит хийнэ. Мөн шалгадагч этгээдийн тогтолцоо, үйл ажиллагааны зохион байгуулалт, түүний хэмжилт, дотоод хяналт үр нөлөөтэй эсэхэд дүгнэлт өгч, тэдгээрийг сайжруулах чиглэлээр гүйцэтгэлийн аудит хийнэ.



Арвилан хэмнэлттэй байх зарчим нь нөөцийн зардлыг хамгийн бага байлгах явдал юм. Ашиглаж буй нөөц нь хамгийн боломжит үнээр зохистой чанар, тоо хэмжээгээр тогтоосон хугацаанд бэлэн байх ёстой.



Үр ашигтай байх зарчим нь боломжит нөөцөөс хамгийн их үр ашиг хүртэхийг хэлнэ. Энэ нь чанар, тоо хэмжээ, хугацааны хувьд ашиглаж буй нөөц, хүрсэн үр дүнгийн хоорондох харилцан хамаарлаас шалтгаална.



Үр нөлөөтэй байх зарчим нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилгыг биелүүлж, төлөвлөсөн үр дүнд хүрэхтэй холбоотой арга хэрэгслийг үнэлнэ.



НИЙЦЛИЙН АУДИТ

Нийцлийн аудитын зорилго

Шалгадагч этгээд үйл ажиллагаандаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актыг хэрэгжүүлж байгаа эсэхэд Төрийн аудитын байгууллага нийцлийн аудит хийнэ. Мөн шалгадагч этгээдийн мөрдөж байгаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон буад эрх зүйн актын нийцэлд аудит хийнэ.



Нийцлийн аудит нь шалгаж буй зүйл эрх бүхий этгээдийн тогтоосон эрх зүйн актад нийцэж байгаа эсэхэд чиглэдэг.




Нийцлийн аудитыг шалгадагч этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн гүйлгээ, мэдээлэл, мөрдвөл зохих хууль тогтоомжид бүх материаллаг талаараа нийцсэн эсэхийг үнэлэх замаар хийнэ.



Төрийн аудитын байгууллага нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн аудиттай хослуулан хийж болно.

2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

- Төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд аудит хийх;
- Олон улсын байгууллага, гадаад орны санхүүжилтээр ажилладаг байгууллага, аж ахуйн нэгж, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд тэдний хүсэлтээр аудит хийх;
- Засгийн газрын тусгай сан, төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө болон олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс Монгол Улсын Засгийн газар, төсвийн байгууллагад олгосон зээл, тусламж, хандивын ашиглалт, зарцуулалт, үр дүнд аудит хийх;
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, түүний үр дүнд аудит хийх;
- Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, зарцуулалтад аудит хийх;
- Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд, түүнчлэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийх;
- Орон нутгийн захиргааны болон төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн тайланд аудит хийх;
- Орон нутгийн төсвийн жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх;



2.3 ТӨРИЙН АУДИТЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

Төрийн аудитын байгууллага нь төрийн болон албаны, байгууллагын, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан журмын дагуу улирал бүр гаргаж, өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлж, мэдээлэл авах хүсэлт гаргасан этгээдэд аудитын тайланг хуульд заасан журмын дагуу өгч болно.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх болон хуулиар хориглосноос бусад тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний

зөвшөөрснөөр Төрийн аудитын байгууллагын албан хаагч аудитын тайлангийн талаар олон нийт, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд журмын дагуу мэдээлэл өгч болно.

Аудитын тайлан, үр дүнг олон нийтэд мэдээлснээр төсвийн хөрөнгө, нөөцийн хадгалалт хамгаалалтад хариуцлагатай хандах боломж ард иргэдэд нээгдэж, улмаар төрийн захиргааны үр ашиг, хариуцлага, үр нөлөө, ил тод байдал дээшилдэг гэсэн Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага (INTOSAI)-ын зарчмыг бид дагаж мөрддөг.



Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь байгууллагын танилцуулга, үйл ажиллагаа, хийж гүйцэтгэсэн аудитын дүн, тайланг хэрэглэгчдэд ил тод, нээлттэй мэдээлэх зарчмын хүрээнд холбогдох мэдээллүүдийг audit.mn, open.audit.mn цахим хуудсуудаар болон байгууллагын фэйсбүүк хуудсанд байршуулж байгаа бөгөөд байгууллагын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, холбогдох бусад мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь shilendans.gov.mn нэгдсэн цахим сангаар мэдээлж байна.

Цахим хуудас:  https://audit.mn/?page_id=651

Фэйсбүүк хуудас:  www.facebook.com/AuditSelenge

Шилэн данс:  <https://shilendans.gov.mn/org/1440>



Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар
/Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын байр, өргөтгөл/

✉ selenge@audit.gov.mn



www.audit.mn

(+976)7036-3040

☎ (+976)7036-3036

(+976)7036-2442